



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/200

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.12 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх явган хүний гүүрэн гарцын цахилгаан шатны арчлалт, засварын ажлыг хавсралт ёсоор баталж, уг төсөл, арга хэмжээг дүрмээр хүлээсэн үүргийн дагуу гүйцэтгэж, үр дүнг танилцуулж ажиллахыг “Улаанбаатар лифт” ОНӨТҮГ (Д.Ган-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 245.8 (хоёр зуун дөчин таван сая найман зуун мянган) төгрөгийг “Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “Б”-ийн “7”-д заасан “Гүүр, хоолой, туннелийн засварын ажил”-ын хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Б.Бямбасүрэн)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын алба (М.Баяраа)-нд, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Д.СУМЬЯАБАЗАР

1110200932

Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
...*03 дугаар*... сарын *10*... ны өдрийн  
...*7320*... захирамжийн  
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ  
ЯВГАН ХҮНИЙ ГҮҮРЭН ГАРЦНЫ ЦАХИЛГААН ШАТНЫ  
АРЧЛАЛТ, ЗАСВАРЫН АЖИЛ

(сая төг)			
№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
1	Явган хүний гүүрэн гарцны цахилгаан шатны арчлалт, засварын ажил	245.8	245.8
	ДҮН	245.8	245.8